



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн
шүүхийн тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/523/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр
Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Отгонбаяр
Утас: 315558 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn

Аудитор: Т.Гандолгор
Утас: 325093 Цахим хаяг: gandolgort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-08-25 № 281
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Шүүх байгуулах тухай хуулийн 2 дугаар зүйлд “Анхан шатны шүүхийн байршил, тэдгээрийн нутаг дэвсгэрийн харъяаллыг доор дурьдсанаар тогтооно” гэж заасны дагуу Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийг татан буулгаж Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газартай нэгтгэж Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийг байгуулсан байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тайлант онд 5 зорилтын хүрээнд 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 82.0 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>28,738,240.00</u>	<u>84,528,434.00</u>
33	АВЛАГА	00.00	13,745,034.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	13,745,034.00
35	БАРАА МАТЕРИАЛ	28,738,240.00	70,783,400.00
354	Хангамжийн материал	28,738,240.00	70,783,400.00
35410	Бичиг хэргийн материал	10,034,650.00	16,794,510.00
35420	Аж ахуйн материал	5,994,300.00	1,573,600.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	10,890,500.00
35450	Барилгын засварын материал	00.00	4,449,400.00
35470	Бусад хангамжийн материал	12,709,290.00	37,075,390.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>576,698,204.25</u>	<u>1,861,203,309.76</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	576,698,204.25	1,861,203,309.76
392	Биет хөрөнгө	575,653,204.20	1,842,453,836.34
39201	Барилга, байгууламж, орон сууц	00.00	461,020,370.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-250,140,286.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,110,078.14	452,808,878.14
39204	Хуримтлагдсан элэгдэл	-31,933,763.34	-118,401,859.79
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	518,695,490.88	1,287,203,843.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	-160,873,176.48	-469,486,803.34
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	192,282,358.43	610,628,302.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	-42,089,343.43	-137,820,341.25
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	19,257,391.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-14,705,101.60
39217	Ном	1,461,560.00	2,312,552.00
39301	Программ хангамж	1,320,000.00	1,320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-274,999.95	-476,666.58
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	17,906,140.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>605,436,444.25</u>	<u>1,945,731,743.76</u>
4	<u>НИЙТ ӨР ТӨЛБӨР</u>	<u>00.00</u>	<u>52,252,142.87</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	52,252,142.87
413	Өглөг	00.00	52,252,142.87
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,436,412.87
4136	Бусад өглөг	00.00	50,815,730.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	50,815,730.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	605,436,444.25	1,893,479,600.89
51	Засгийн газрын хувь оролцоо	605,436,444.25	1,893,479,600.89
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	00.00	1,021,159,724.48
51101	Өмч: - төрийн	00.00	1,021,159,724.48
512	Хуримтлагдсан үр дүн	605,436,444.25	872,319,876.41
51210	Өмнөх үеийн үр дүн	501,974,301.67	605,436,444.25
51220	Тайлант үеийн үр дүн	103,462,142.58	266,883,432.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	605,436,444.25	1,945,731,743.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,170,200,013.68	11,700,049,679.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	156,868,413.68	677,538,166.85
120	Нийтлэг татварын бус орлого	156,868,413.68	677,538,166.85
120009	Бусад орлого	6,320,000.00	5,490,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	144,825,513.68	672,048,166.85
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	5,722,900.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,013,331,600.00	11,022,511,513.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,988,361,600.00	11,005,121,479.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,988,361,600.00	11,005,121,479.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,970,000.00	17,390,034.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,930,000.00	13,250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,040,000.00	4,140,034.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,066,737,871.10	11,412,357,258.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,066,737,871.10	11,412,357,258.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,966,856,561.66	11,315,399,873.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,998,472,538.35	8,896,337,423.97
210101	Үндсэн цалин	1,928,248,100.05	5,059,114,480.06
210102	Нэмэгдэл	533,414,753.39	1,998,067,835.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	286,047,721.95	834,535,114.57
210104	Урамшуулал	250,761,962.96	1,004,619,993.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	381,651,207.68	1,119,580,819.11
210201	Тэтгэврийн даатгал	260,808,673.74	766,047,296.95
210202	Тэтгэмжийн даатгал	30,975,547.89	87,539,242.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,556,877.22	43,748,957.25
210204	Ажилгүйдлийн даатгал	13,945,193.25	42,411,033.98
210205	Эрүүл мэндийн даатгал	59,364,915.58	179,834,288.28

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	190,190,363.38	420,709,930.01
210301	Гэрэл, цахилгаан	12,069,286.41	52,842,711.48
210302	Түлш, халаалт	14,894,423.30	39,083,522.04
210303	Цэвэр, бохир ус	3,876,726.86	12,799,096.49
210304	Байрны түрээс	159,349,926.81	315,984,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	204,430,852.21	345,570,552.36
210401	Бичиг хэрэг	86,080,010.00	147,077,525.00
210402	Тээвэр, шатахуун	15,989,500.00	19,424,501.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	69,152,482.21	149,047,612.36
210404	Ном, хэвлэлийн зардал	3,246,250.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,246,250.00	1,980,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,732,100.00	25,071,814.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	2,968,200.00
2105	Нормативт зардал	1,899,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,899,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,268,150.00	92,691,680.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,273,000.00	842,600.00
210604	Урсгал засвар	29,995,150.00	91,849,080.00
2107	Томилолт, зочны зардал	450,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	450,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,139,768.94	77,435,363.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,661,182.00	67,974,185.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,237,960.94	4,575,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	287,126.00	1,229,378.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	514,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,876,500.00	3,142,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,354,681.10	363,074,105.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	7,378,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	98,354,681.10	355,696,105.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,881,309.44	96,957,384.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,503,000.00	11,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,503,000.00	11,400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	91,378,309.44	85,557,384.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,378,309.44	85,557,384.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	103,462,142.58	287,692,421.73
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	20,808,989.57
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	20,808,989.57
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-20,808,989.57
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	103,462,142.58	266,883,432.16

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,013,331,600.00	11,023,001,513.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	800,000.00	490,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	800,000.00	490,000.00
120009	Бусад орлого	800,000.00	490,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,012,531,600.00	11,022,511,513.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,988,361,600.00	11,005,121,479.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,988,361,600.00	11,005,121,479.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,170,000.00	17,390,034.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,930,000.00	13,250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,240,000.00	4,140,034.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,966,307,710.00	10,998,768,513.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,966,307,710.00	10,998,768,513.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,866,426,400.56	10,888,066,094.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,998,472,538.35	8,896,337,423.97
210101	Үндсэн цалин	1,928,248,100.05	5,059,114,480.06
210102	Нэмэгдэл	533,414,753.39	1,998,067,835.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	286,047,721.95	834,535,114.57
210104	Урамшуулал	250,761,962.96	1,004,619,993.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	381,651,207.68	1,118,144,406.24
210201	Тэтгэврийн даатгал	260,808,673.74	764,610,884.08
210202	Тэтгэмжийн даатгал	30,975,547.89	87,539,242.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,556,877.22	43,748,957.25
210204	Ажилгүйдлийн даатгал	13,945,193.25	42,411,033.98
210205	Эрүүл мэндийн даатгал	59,364,915.58	179,834,288.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	190,190,363.38	420,709,930.01
210301	Гэрэл, цахилгаан	12,069,286.41	52,842,711.48
210302	Түлш, халаалт	14,894,423.30	39,083,522.04
210303	Цэвэр, бохир ус	3,876,726.86	12,799,096.49
210304	Байрны түрээс	159,349,926.81	315,984,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	200,471,072.21	308,025,571.36
210401	Бичиг хэрэг	89,894,530.00	112,273,845.00
210402	Тээвэр, шатахуун	15,989,500.00	26,350,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	69,152,482.21	149,047,612.36
210404	Ном, хэвлэл	3,246,250.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,732,100.00	1,980,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,456,210.00	18,373,214.00

2105	Нормативт зардал	2,919,000.00	1,160,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,919,000.00	1,160,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,132,450.00	82,311,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,137,300.00	842,600.00
210604	Урсгал засвар	29,995,150.00	81,468,800.00
2107	Томилолт, зочны зардал	450,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	450,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,139,768.94	53,999,363.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,661,182.00	44,538,185.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,237,960.94	4,575,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	287,126.00	1,229,378.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	514,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,876,500.00	3,142,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	7,378,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	7,378,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,881,309.44	110,702,418.42
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,503,000.00	11,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,503,000.00	11,400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	91,378,309.44	99,302,418.42
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,378,309.44	99,302,418.42
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>47,023,890.00</u>	<u>24,233,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	47,026,890.00	24,233,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	47,026,890.00	24,233,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	47,026,890.00	24,233,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	47,026,890.00	24,233,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-47,026,890.00</u>	<u>-24,233,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-3,000.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,000.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	501,974,301.67	-	501,974,301.67
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-	-	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	501,974,301.67	-	501,974,301.67
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	-	-	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	-	-	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	-	-	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	103,462,142.58	-	103,462,142.58
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	605,436,444.25	-	605,436,444.25
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	605,436,444.25	-	605,436,444.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	-	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	605,436,444.25	-	605,436,444.25
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	-	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	1,021,159,724.48	00.00	00.00	-	1,021,159,724.48
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	-	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	-	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	266,883,432.16	-	266,883,432.16
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,021,159,724.48	00.00	872,319,876.41	-	1,893,479,600.89

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,164,838,600.00	10,919,599,094.58	245,239,505.42	97.80%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,164,838,600.00	10,919,599,094.58	245,239,505.42	97.80%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,150,638,600.00	10,908,199,094.58	242,439,505.42	97.83%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,971,706,100.00	8,896,337,423.97	75,368,676.03	99.16%
210101	Үндсэн цалин	5,154,705,300.00	5,059,114,480.06	95,590,819.94	98.15%
210102	Нэмэгдэл	1,931,910,100.00	1,998,067,835.52	-66,157,735.52	103.42%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	805,107,600.00	834,535,114.57	-29,427,514.57	103.66%
210104	Урамшуулал	1,079,983,100.00	1,004,619,993.82	75,363,106.18	93.02%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,121,463,300.00	1,118,144,406.24	3,318,893.76	99.70%
210201	Тэтгэврийн даатгал	769,262,700.00	764,610,884.08	4,651,815.92	99.40%
210202	Тэтгэмжийн даатгал	88,050,100.00	87,539,242.65	510,857.35	99.42%
210203	ҮОМШӨ-ний даатгал	44,025,100.00	43,748,957.25	276,142.75	99.37%
210204	Ажилгүйдлийн даатгал	44,025,100.00	42,411,033.98	1,614,066.02	96.33%
210205	Эрүүл мэндийн даатгал	176,100,300.00	179,834,288.28	-3,733,988.28	102.12%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	459,164,300.00	420,709,930.01	38,454,369.99	91.63%
210301	Гэрэл, цахилгаан	67,713,800.00	52,842,711.48	14,871,088.52	78.04%
210302	Түлш, халаалт	56,319,700.00	39,083,522.04	17,236,177.96	69.40%
210303	Цэвэр, бохир ус	14,234,000.00	12,799,096.49	1,434,903.51	89.92%
210304	Байрны түрээс	320,896,800.00	315,984,600.00	4,912,200.00	98.47%
2104	Хангамж, бараа материалын зардал	358,300,800.00	303,925,571.36	54,375,228.64	84.82%
210401	Бичиг хэрэг	134,920,500.00	111,818,845.00	23,101,655.00	82.88%
210402	Тээвэр, шатахуун	39,883,200.00	26,350,000.00	13,533,200.00	66.07%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	161,060,000.00	149,047,612.36	12,012,387.64	92.54%
210404	Ном, хэвлэл	358,300,800.00	303,925,571.36	54,375,228.64	84.82%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,493,600.00	1,980,900.00	512,700.00	79.44%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,943,500.00	14,728,214.00	5,215,286.00	73.85%
2105	Нормативт зардал	2,041,900.00	1,160,000.00	881,900.00	56.81%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,041,900.00	1,160,000.00	881,900.00	56.81%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	154,372,600.00	106,544,400.00	47,828,200.00	69.02%
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,172,600.00	25,075,600.00	97,000.00	99.61%
210602	Тавилга	40,000,000.00	00.00	40,000,000.00	0.00%
210604	Урсгал засвар	89,200,000.00	81,468,800.00	7,731,200.00	91.33%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	76,211,600.00	53,999,363.00	22,212,237.00	70.85%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	58,469,300.00	44,538,185.00	13,931,115.00	76.17%

	үйлчилгээний төлбөр хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	0.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,850,000.00	4,575,000.00	3,275,000.00	58.28%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,000,000.00	1,229,378.00	1,770,622.00	40.98%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,416,500.00	514,000.00	902,500.00	36.29%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,975,800.00	3,142,800.00	833,000.00	79.05%
210807	Газрын төлбөр	1,500,000.00	00.00	1,500,000.00	0.00%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7378000.00	7378000.00	0.00	100.00%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,378,000.00	7,378,000.00	0.00	100.00%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14200000.00	11400000.00	2,800,000.00	80.28%
2132	Бусад урсгал шилжүүлэг	14200000.00	11400000.00	2,800,000.00	80.28%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14200000.00	11400000.00	2,800,000.00	80.28%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,164,838,600.00	10,919,564,094.58	245,274,505.42	97.80%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,164,838,600.00	10,919,564,094.58	245,274,505.42	97.80%
132001	Улсын төсвөөс санхүүжих	11,164,838,600.00	10,919,564,094.58	245,274,505.42	97.80%
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	331.00	284.00	47.00	85.80%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	140.00	137.00	3.00	97.86%
620001	Удирдах ажилтан	02.00	02.00	0.00	100.00%
620002	Гүйцэтгэх ажилтан	91.00	88.00	3.00	96.70%
620003	Үйлчлэх ажилтан	47.00	47.00	0.00	100.00%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	140.00	137.00	3.00	97.86%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	61.00	60.00	1.00	98.36%
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	01.00	01.00	0.00	100.00%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	46.00	46.00	0.00	100.00%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,390,034.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,645,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,645,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,645,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,645,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,745,034.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17390034.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,390,034.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,250,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,140,034.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 129,685.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 129,685.4 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 2 зөрчилд зөвлөмж өгсөн.

6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн ангилал буруу 22,323.01 мянган төгрөгийн хөрөнгө, ашиглагдах жилийг хасах утгатай тайлагнасан 64,078.43 мянган төгрөгийн хөрөнгө, Элэгдэл тооцоогүй 223.11 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэснийг;	1	86,624.6			1	86,624.6	1	86,624.6				
Төсвийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан.Төсвийн гүйцэтгэлийн зардлыг санхүүжүүлэх орлогын дүнг 103,402.42 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг;	1	103,402.2			1	103,402.2	1	103,402.2				
Дүн	2	190,027.0			2	190,027.0	2	190,027.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хөрөнгийн тооллогын комисст нягтлан бодогчийг оруулсан.	1						1					
Хөрөнгийн тооллогыг 2025.12.04-2025.12.19 хүртэл зохион байгуулсан нь 2025.12.31 өдрийн үлдэгдлээр тоолсон. Тооллогоос хойш хөдөлгөөн гарсан нь үнэн бодитой биш байна.	1						1					

Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Шатахууныг их хэмжээний нөөц бүрдүүлсэн байна.	1	10,890.5			1	10,890.5						
Бэлтгэн нийлүүлэгч байгуулгаатай байгуулсан гэрээгээ дүгнээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй ААН-д санхүүжилт бүрэн олгосон байна	1	73,870.8			1	73,870.8						
Авлагын 13,745.0 мянган төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	13,745.0			1	13,745.0						
Урсгал засвар хийх ажлын тоо хэмжээ, төсвийг нийт дүнгээр нь төлөвлөөгүй, харьцуулсан үнийн судалгаагүй, гэрээ байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн.	1	31,179.0			1	31,179.0						
Дүн	6	129,685.4			4	129,685.4	2					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 70,040.0 мянган төгрөгийн 7 мэдээллийг мэдээлээгүй, нийт 31 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	70,040.0					1	70,040.0
Дүн	1	70,040.0					1	70,040.0



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 92/А0090344

Улаанбаатар хот

НТАГ-2026/523/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тооцоо, судалгаагүй 10,890,500.00 (арван сая найман зуун ерэн мянга) төгрөгийн бараа материалыг их хэмжээгээр бэлтгэсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Тооцоо судалгаагүй шатахууныг их хэмжээгээр бэлтгэн хадгалж байгаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн тамгын газрын дарга Л.Наянтай, нягтлан бодогч Б.Номин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ

Т.ГАНДОЛГОР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1425090167



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 90/АУБАТ.544

Улаанбаатар хот

НТАГ-2026/523/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, 31,179,020.00(гучин нэгэн сая нэг зуун далан есөн мянга хорь) төгрөгийн засварын ажлыг гүйцэтгэх ажлын тоо хэмжээ, батлагдсан төсөвгүйгүйгээр шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Төндөр шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 33 дугаар зүйлийн 33.1-д "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно" заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол," заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Урсгал засварын ажлыг гүйцэтгэх ажлын тоо хэмжээ, батлагдсан төсөвгүй, худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, журмыг мөрдөөгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн тамгын газрын дарга Л.Наянтай, нягтлан бодогч Б.Номин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ

Т.ГАНДОЛГОР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1425090165



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 89/А0270334

Улаанбаатар хот

НТАГ-2026/523/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай байгуулсан гэрээг дүгнээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй аж ахуйн нэгжид 73,870,800.00 (далан гурван сая найман зуун далан мянга найман зуу) төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Бэлтгэн нийлүүлэгчтэй байгуулсан гэрээг дүгнэлгүйгээр санхүүжилт олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн тамгын газрын дарга Л.Наянтай, нягтлан бодогч Б.Номин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ
Т.ГАНДОЛГОР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090163



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 86/А0290344

Улаанбаатар хот

НТАГ-2026/523/НА-СТН-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн тамгын газрын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Авлагын дансны 13,745,000.00 (арван гурван сая долоон зуун дөчин таван мянга) төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, акт үйлдээгүй баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасантай нийцээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол албаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1.Авлагын дансны үлдэгдлийг тооцоо нийлж, акт үйлдээгүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн тамгын газрын дарга Л.Наянтай, нягтлан бодогч Б.Номин-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ

Т.ГАНДОЛГОР

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар

1426090161